



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 30 өдөр

Дугаар

9/49

Номгон

Аймаг орон нутгийн үйл ажиллагааг
олон нийтэд сурталчлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.9, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг орон нутгийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор МҮОНТВ “Монгол түмний мэнд” нэвтрүүлэгт оролцох ажлыг 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсугай.

2. Монголын Үндэсний олон нийтийн радио телевизтэй хамтран ажиллах гэрээг байгуулж, нэвтрүүлгийн төлбөр болох 8,000,000 (Найман сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. Тухайн арга хэмжээг чанарын өндөр түвшинд зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс (Т.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-т даалгасугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ

